

БАТЛАВ.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ЕРӨНХИЙ
ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.НАРАНТУЯА

АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2017 оны 11 дугаар сарын 16

№ 2017 1 1 27 15 2 Улаанбаатар хот

Энэхүү ажил гүйцэтгэх гэрээ /цаашид "Гэрээ" гэх /-г

Нэг талаас: Эрүүл мэндийн хөгжлийн төв /цаашид "Захиалагч" гэх/ түүнийг төлөөлж Эм, эмнэлгийн хэрэгслийн албаны дарга Г.Цэцэнсанаа

Нөгөө талаас: Иргэн Н.Амараа нар харилцан тохиролцож байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү гэрээ нь Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын санхүүжилттэй ЭМХТ-ийн захиалгаар хийгдэх "Антибиотик эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх нь, эмийн мэргэжилтний ёс зүй харилцаа хандлага" сэдэвт 4 хоногийн сургалтыг Дорноговь аймагт зохион байгуулахад талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлоход оршино.
- 1.2 Гэрээнд зааснаас бусад нэмэлт өөрчлөлт оруулах тохиолдолд талууд харилцан тохиролцож бичгээр мэдэгдэх үүрэгтэй.

ХОЁР. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

- 2.1. Ажил гүйцэтгэгч нь энэхүү гэрээний 1.1.-д заасан ажлыг 2017 оны 11 сарын 19-өдрөөс 2017 оны 11 дүгээр сарын 24-ны өдөр хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэнэ.

ГУРАВ. АЖЛЫН ХӨЛС

- 3.1 Гэрээт зохион байгуулах, туслахын ажлын хөлсийг 132000₮ /нэг зуун гучин хоёр мянган төгрөг/ -өөр тогтов.

ДӨРӨВ. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ ҮҮРЭГ

- 4.1. Захиалагч нь гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гүйцэтгэлийн тайланг 2017 оны 11 дүгээр сарын 15-ны дотор хүлээн авч, дүгнэнэ.
- 4.2. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын санхүүжилттэй ЭМХТ-ийн захиалгаар хийгдэх "Антибиотик эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх нь, эмийн мэргэжилтний ёс зүй харилцаа хандлага" сэдэвт сургалтыг чанарын өндөр түвшинд зохион байгуулж гүйцэтгэхийг шаардах.
- 4.3. Гэрээт зохион байгуулах, туслахын хөлсийг Хаан банк-ны Н.Амараа эзэмшигчтэй 5225146619 дугаар данс руу 2017 оны 11 сарын 20-ны дотор шилжүүлнэ.

ТАВ. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ ҮҮРЭГ

- 5.1. Гэрээнд заасан ажлыг тогтоосон хугацаанд гүйцэтгэнэ.
- 5.31. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын санхүүжилттэй ЭМХТ-ийн захиалгаар хийгдэх “Антибиотик эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх нь, эмийн мэргэжилтний ёс зүй харилцаа хандлага” сэдэвт сургалтыг чанарын өндөр түвшинд зохион байгуулж гүйцэтгэнэ.
- 5.32. Ажлыг биечлэн гүйцэтгэнэ.
- 5.7. “Антибиотик эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх нь, эмийн мэргэжилтний ёс зүй харилцаа хандлага” сэдэвт сургалтын өмнө оролцогчдоос мэдлэг сорих шалгалт тестээр авч түвшинг тогтоож, сургалтын дараа дахин шалгалтыг тестээр авч сургалтын чанарыг үнэлнэ.

ЗУРГАА. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

- 6.31 Гэрээний үүрэг хэрэгжих явцад Талуудын хамтын ажиллагааны ёс зүйг эрхэмлэн байгууллагын нэр хүнд болон түүнд хамаарах бусад үнэт зүйлсийг хүндэтгэж ажиллана.
- 6.32 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс учруулсан хохирлыг гэм буруутай тал нь хохирогч талдаа нөхөн төлөх үүрэгтэй.
- 6.33 Гэрээг 2 хувь үйлдэж “захиалагч” тал нэг хувийг “гүйцэтгэгч” тал нэг хувийг тус тус хадгална.

ДОЛОО. БУСАД ЗҮЙЛ

- 3.2. Ажил гүйцэтгэх явцад гэрээнд оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлт нь зөвхөн бичгээр хийгдэж талуудын гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

ТӨЛӨӨЛЖ:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ЭМХТ, Эм, эмнэлгийн
хэрэгслийн албаны дарга

Г.Цэцэнсанаа



ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ЭМГ-ын мэргэжилтэн Н.Амараа
/РД:ВЮ66100507/ Н.Амараа